



БУЛГАН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТОЛООЛОГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТӨГТООЛ

2021 оны 03 сарын 17 одор Дугаар 31

Булган

Г Журам батлах тухай

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 ж, 20 дугаар зүйлийн 20.1.14, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1-ын 4 дэх заалтыг үндэслэн ТӨГТООХ нь:

1. Булган аймгийн Засаг даргын нэрэмжит сургалтын төлбөрийн "Тэтгэлэг олгох журам"-ыг нэгдүгээр, сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Сурагчдын элсэлтийн ерөнхий шалгалт, урлаг, спортын амжилтыг харгалзан урамшуулалт олгох ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс /Д.Оюунбилэг/, аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар /Э.Түвшинмөнх/-д тус тус үүрэг болгосугай.



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн
31. дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ СУРГАЛТЫН
ТӨЛБӨРИЙН ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМ
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1 Энэхүү журмаар Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуулийн бакалаврын боловсрол эзэмших өдрийн ангид элсэн ороход элсэлтийн еренхий шалгалт, урлаг, спортын үнэмлэхүй амжилтыг үнэлж, сургачдад сургалтын тэтгэлэг олгох харилцааг зохицуулна.
- 1.2 Магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын сургалтын байгууллагад бакалаврын боловсрол эзэмших өдрийн ангид еренхий боловсролын сургуулиа төгсөн шинээр элсэн орж байгаа сурлага, урлаг, спортоор үе тэнгийнхнийгээ манлайлагч сургачид олгох сургалтын төлбөрийг оюутны сургалтын тэтгэлэг /цаашид тэтгэлэг гэх/ гэнэ.
- 1.3 Аймгийн Засаг даргын томилсон "Сургалтын тэтгэлэг" олгох сонгон шалгаруулах ажлын хэсэг /цаашид ажлын хэсэг гэх/ энэхүү журам болон бусад хууль тогтоомжийг баримтлан тэтгэлэг шалгаруулах ажиллагааг зохион байгуулна.
- 1.4 Тэтгэлгийг сурлага, урлаг, спортын амжилтад тавигдах шалгуур үзүүлэлтийн дагуу нэг жилийн тэтгэлгийг олгоно.

ХОЁР. СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ТЭТГЭЛЭГ ОЛГОХ

- 2.1 Еренхий боловсролын сургуулийг сурлага, урлаг, спортын амжилтаар тэргүүлж, Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуульд бакалаврын боловсрол эзэмших өдрийн ангид зохих журмын дагуу анх удаагаа элсэн орох тус аймгийн харьят сургачдад сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно.
- 2.2 Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа еренхий боловсролын сургуульд сүүлийн 5 хичээлийн жилд суралцсан байна.
- 2.3. Тухайн онд 12 дугаар анги төгссөн төгсөгч байна.
- 2.4 Сургалтын тэтгэлэг олгоходо тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрөөс 100 хүртэлх хувиар тооцож олгоно.
- 2.5 Суралцах идэвх сайтай, сурлага, урлаг, спортын үнэмлэхүй ёндер амжилт үзүүлж аймаг орон нутгийн нэрийг гаргасан сургачдад олгоно.

2.6 Сургалтын төлберийн тэтгэлэгт тэнцсэн иргэдэд аймгийн Засаг даргын батламж олгож, батламжийг гардуулах үйл ажиллагааг зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

2.7 Урамшууллыг 3 чиглэлд олгох бөгөөд элсэлтийн ерөнхий шалгалтын амжилтаар жил бүр 20, урлагийн амжилтаар 5, спортын амжилтаар 5, нийт 30 хүртэлх суралцаагчдад олгох ба дараах ерөнхий шалгуурыг хангасан байна.

2.7.1 Элсэлтийн ерөнхий шалгалтын амжилтаар:

2.7.1.1. Монгол хэл бичгийн шалгалт, элсэлтийн ерөнхий шалгалтын монгол хэл, математик, монгол улсын түүх, англи хэл, орос хэл, физик, хими, биологи, газарзүй, нийгмийн тухай мэдлэг хичээлүүдээс сонгож шалгалт өгсөн байх,

2.7.1.2 Тухайн шалгуулагчийн шалгалт өгсөн бүх хичээлүүдийн дундаж хэмжээст оноо 650-аас дээш байх

2.7.1.3 Хэмжээст онооны дундажаар аймгийн хэмжээнд эхний 20-т багтсан байх

2.7.1.4 Аймгийн Засаг даргын сургалтын тэтгэлэг олгох журмын гэрээг дагаж мердэх

2.7.2 Урлагийн амжилтаар:

2.7.2.1 Улс, аймаг, бүсийн уралдаанд шагналт байр эзэлсэн байх,

2.7.2.3 Хүмүүжлийн болон ёс суртахууны доголдолгүй байх

2.7.2.4 Эрүүл мэндийн хувьд суралцах боломжтой байх,

2.7.3 Спортын амжилтаар:

2.7.3.1 Хүүхдийн олимп, дэлхий, тив, олон улсын тэмцээнд медальт болон тусгай байранд шалгарсан байх,

2.7.3.2 Олон улсын уралдаан тэмцээнд медальт байранд шалгарсан байх

2.7.3.3 Аймаг, орон нутгаа төлөөлөн сүүлийн 3 жил шигшээ тэмцээнд оролцсон байх

2.7.3.4.Тухайн спортын төрлөөр цол, зэрэгтэй байх

ГУРАВ. ТЭТГЭЛЭГ АВАХАД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

3.1 Анкет, өргөдөл, цээж зураг 2ш /3*4/

3.2 Сургууль, анги удирдсан багш ба нийгмийн ажилтны тодорхойлолт /холбогдох удирдлагын тамга, гарын үсэгтэй албан бичиг байх/

3.3 Тэтгэлэг хүсэгчийн гаргасан сурлага, урлаг, спорт, олимпиад, уралдаанд оролцсон амжилт, байдлыг гэрчлэх материалын хуулбар /зөвхөн

суулийн 2 хичээлийн жилд гаргасан амжилтыг тооцно. Нотариатаар баталгаажуулах шаардлагагүй/

3.4 Ам бүлийн тодорхойлолт /Багийн Засаг даргын тамга тэмдэг, гарын үсгээр батлагаажсан байх, өөрийн иргэний үнэмлэхний хуулбар/

3.5. Боловсролын үнэлгээний төвөөс олгосон дүнгийн батламж хуудасны хуулбар

3.6 Сургалтын төлбөрийн нэхэмжлэх /сургуулийн албан ёсны тамга тэмдэгтэй, хуулбарлахгүй/

3.7 Бүрдүүлсэн материалыа дээрх дарааллын дагуу жил бүрийн 07 дугаар сарын 18-ны өдрөөс 8 дугаар сарын 10-ний өдрийн хооронд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлнэ.

3.8 Хугацаа хоцроосон болон дутуу материалыг хүлээж авахгүй бөгөөд хүлээн авсан материалыг буцаан олгохгүй.

ДӨРӨВ. САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

4.1 Урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийн хэмжээг тухайн жилийн хөтөлбөрийн төсөөт тусгана.

4.2 Шаардагдах хөрөнгийг тухайн жилийн сургалтын төлбөрийн хэмжээнээс шалтгаалан санхүүжуулнэ.

ТАВ. ХАРИУЦЛАГА

5.1 Урамшуулал олгохтой холбоотой баримт бичгүүдийг хуурамчаар үйлдэх, тэтгэлгийг зориулалтын бусаар зарцуулсан тохиолдолд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---оОо---

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн
11.. дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ “СУРГАЛТЫН
ТӨЛБӨРИЙН ТЭТГЭЛЭГ” ОЛГОХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН
АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн ахлагч:

Аймгийн Засаг дарга

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Боловсрол, соёл урлагийн газрын дарга
- Биетийн тамир спортын газрын дарга
- Гэр бүл, хуухэд залуучуудын хөгжлийн газрын дарга
- Боловсрол, соёл, урлагийн газрын Удирдлага төлөвлөлт, захиргаа аж ахуйн албаны дарга
- Боловсрол, соёл, урлагийн газрын Соёлын бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн